

**ЕБС-ийн багш, ажилчдын 2023 оны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт**

**2023 оны 12 сарын 07**

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ  | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин | Хүрэх түвшин |             | Хэрэгжилт   | Хувь |
|---|---|--|--------------|--------------|-------------|---|------|
|   |   |  |              | Эхний хагас  | Жилийн эцэс |   |      |
| 1 | ЭЕШ-800 сургалт   | ЭЕШ-г удирдах, дүн шинжлэх аймгийн удирдлагын систем EYESH 800 web.app | 0            | 10           | -           | Сурлагын амжилтыг хэрхэн ахиулах вэ, хүүхэд бүртэй хэрхэн тулж ажиллах вэ, судалгаанд суурилан үр дүнгээ хэрхэн гаргах вэ, төгсөгчдийн амжилтыг ахиулах зорилгоор ЭЕШ- 800 системийг ашиглах сургалтанд ЗАН-ийн ахлагч болон ЭЕШ-д бэлтгэж буй багш нар, захирал, менежерүүд 13 хүний бүрэлдэхүүнтэй сургалтанд хамрагдлаа. ЭЕШ800 системийг ашиглан суралцагчдын онлайн сорилыг 3 удаа зохион байгуулсан. Онлайн сорилын үр дүнг тухайн цаг бүрт нь суралцагч, багш нарт, хэрхэн ажиллах болон ажиллаж байгаа талаар мэдээлэл өгч ажилласан. Суралцагчдын хувьд аппликейшнаа ашиглаж хоцрогдлоо нөхөх чадвар дутмаг байсан. Багш нар систем дээрээ ажиллаж суралцагчийн алдаан дээр ажиллаж хоцрогдлоо нөхөж авч байгаа нь давуу тал байлаа. | 100% |
| 2 | Багшийн болон сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий үр дүн | Ерөнхий үр дүнд хийсэн дүн шинжилгээ, цаашид анхаарах зүйл             | 3            | 8            | 18          | Багшийн болон сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн тайлант сургалтанд захирал, сургалтын менежерүүд, ЗАН-ийн ахлагч гэсэн 13 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдлаа. Сургалтаар stat.eec.mn хаягнаас өөрийн сургуулийн судлагдахуун болгоны дүн, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дүнг хийж нэгдсэн дүгнэлт гарган багш нарт мэдээлэх байлаа. Нэгдсэн үнэлгээг гарган багш, ажилчдад мэдээлэл хүргэн ажилласан. Үр дүнгээ ахиулан дараа дараагийн гүйцэтгэлд амжилттай сайн үнэлгээ авахаар зорьж ажиллалаа.  | 100% |

|   |  |   |   |    |   |  |      |
|---|--|---|---|----|---|--|------|
| 3 | Орон нутгийн БШУГ-н үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, ЕБС-н үнэлгээ хариуцсан сургалтын менежерийг чадавхжуулах цахим сургалт | БАГУ-г хэрхэн зохион байгуулах, бааз мэдээллийг хэрхэн үүсгэх, үнэлгээн ий үр дүнд хоцрогдсон агуулгыг арилгэж сурлагат ахиц гаргах | 3 | 3  | - | БҮТ-өөс зохион байгуулсан боловсролын үнэлгээний хүрээ болон багшийн үнэлгээний чиг хандлага, өнөөгийн байдал, олон улсын чиг хандлага сургалтанд сургалтын менежерүүд хамрагдсан. Сургалтын агуулгыг багш гарт түгээн ажилласан бөгөөд энэхүү мэдээлэлд 51 хамрагдсан.  | 100% |
| 4 | Мэргэжлийн багш нарын сургалт / ТНУ, Англи хэл   | Даалгавар боловсруулах, харилцан туршлага солилцох, Англи хэлний ментор багш бэлтгэх  | 0 | 12 | - | Англи хэлний багш Э.Шинэцэцэг Америкийн элчингийн газраас зохион байгуулж буй үндэсний сургагч багш бэлтгэх онлайн сургалтад бүтэн жилийн хугацаагаар суралцан төгссөн. Мөн Дундговь аймгийн Англи хэлний Ментор багш нарын хүсэлтийг хүлээн авч нэг өдрийн үйл ажиллагааг 2023.04.21-нд зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд 9г ангид нээлттэй хичээл, 12-р ангийн 58 сурагчид ЭЕШ-д бэлтгэх аргазүй сургалт, багш ажилчдад “Ажил амьдралын тэнцвэр ба сайн сайхан байдлын 5 алхам” сургалт, 10-11-р ангийн 20 сурагчдад АНУ-ын түүх, соёл, боловсролын тухай мэдээлэл, мэргэжлийн багш нарт онол аргазүйн зөвлөгөө өгөх ажлуудыг зохион байгуулсан. | 100% |
| 5 | А/465 болон А/430 -р тушаалыг  | Кабинетийн журам, БАГУ-г зохион   | 0 | 56 | - | А-465 дугаар журмыг нийт 57 багшид танилцуулж шалгуур үзүүлэлтийн дагуу 13 кабинетийг гэрчилгээжүүлсэн. Үүнээс 4 кабинет шинээр байгуулагдсан.   | 100% |

|   | танилцуулах сургалт | байгуулах журам  |   |   |   |  |      |
|---|---------------------|------------------|---|---|---|--|------|
| 6 | Багшийн хөгжил      | Хамтын ажиллагаа | 3 | 4 | - | <p>1. <b>" Багшийн хөгжлийг дэмжих " баруун бүсийн орон нутгийн чадавхжуулах сургалт,</b><br/> Сайхан-Овоо суманд Мандал сургуулиас 2023-11-6/7ны өдрүүдэд зохион байгуулсан баруун бүсийн багш нарт зориулсан "Сургуулийн менежментийн загвар боловсруулсан аргазүй" туршлага хуваалцах сургалтанд сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, МХБийн ахлагч, номын санч гэсэн 17 хүний бүрэлдэхүүнтэй оролцож сургуулийн тулгамдсан асуудал ба сургуулийн гранд дизайныг боловсруулах аргазүйд суралцсан.</p> <p>2. <b>Arplus сургалтын платформоор дамжуулан онлайн хэлбэрээр ажлын байранд хөгжих сургалт,</b><br/> Монгол Улсын засгийн газрын 2022 оны 91дүгээр тогтоол, БШУы сайдын 2022 оны 170дугаар тушаалд үндэслэн багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих цахим платформд түшиглэн явуулах модуль сургалтанд 64 багш ажилтан хамрагдахаар бүртгүүлэн нэг багшийн 120,000 төгрөг нийт 7,680,000 төгрөгийг зарцуулсан бөгөөд нийт багш нарын сургалтанд хамрагдсан байдал 89% хувьтай байлаа.</p> <p>3. <b>" Үнэлгээний нэгж боловсруулах" арга зүй - сургалт,</b><br/> ЕБС-ийн сургалтын менежерүүдийг үнэлгээний онол арга зүйн чиглэлээр чадавхжуулах сургалт 2023 оны 9 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Сургалтыг Боловсролын үнэлгээний төв, Боловсролын ерөнхий газрын сургагч багш нар зохион байгуулж аймгийн БШУГ-ын мэргэжилтнүүд, 19 сургуулийн Үнэлгээ хариуцсан</p> | 100% |

сургалтын менежерүүд хамрагдсан. Сургалтаар сургуулийн менежмент, үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо бататгган, багшийн болон сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үр дүнд үндэслэн Сургуулийн менежментийн зураглал боловсруулан, өөрийн үнэлгээ зохион байгуулах аргачлалд суралцсан үр дүнтэй сургалт болсон.

**4. Магистрийн сургалтад**

“Глобал удирдагч” ИС-н магистрийн ангид физикийн багш БАНХЦЭЦЭГ суралцан төгссөн.

5. Дэлгэрхангай сумын сургуулиас зохион байгуулагдсан байгалийн ухааны ЭЕШ-д бэлтгэж буй багш нарын мэргэжил арга зүй ур чадварыг дээшлүүлэх сургалтанд 11 сарын 10 нд биологи, химийн багш нар хамрагдсан.

**6. УБ хотын Харумо фужи, Сингапурын хөрөнгө оруулалттай дунд сургууль,**

Шинэ Монгол Харумафүжи ЕБС-тай хамтын ажиллагаа зохион байгууллаа. Үйл ажиллагаанд 23 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. Сургуулийн сургалтын үйл ажиллагаа, анги танхим кабинет, орчин нөхцөлийн тохижилтой танилцлаа. Мөн "Хувь хүний хөгжил" сэдэвт сургалтад хамрагдсан.

**7. Үндэсний хэмжээний 1,5,10 жил ажиллаж буй багш нарын сургалт,**

Боловсролын үнэлгээний төвөөс явуулдаг мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтанд 2023 оны 1-р сард МХУЗ-ын 2, Математикийн 2, Хими 1, Физик 1, Биологи 1, Газарзүй 1, ТНУы 3, нийт 11 багш хамрагдсан.

**8.Монгол бичгийн анхан ба дунд шатны сургалт**

Монгол бичгийг хэрэглээг нэмэгдүүлэхээр сургуулийн МХБУЗын багш нар 225 төрийн албан

хаагчдаас анхан, дунд шатны түвшингээр сорил авч түвшинг тогтоосон. 9 байгууллагаас анхан шатанд 33, дунд шатанд 45, цахим ур чадварын шатанд 15 төрийн албан хаагч суралцахаар бүртгэгдсэн.

**9. Улаанбаатар хотын БГДийн 28дугаар сургуулийн санаачилсан хот, хөдөө орон нутгийн**

05-р сард Улаанбаатар хотод номын сангийн орчныг сайжруулах хамтын ажиллагааны төсөл” 2 өдрийн сургалтанд номын санч Ц.Нарханд, Ц.Ууганьям нар хамрагдсан. Мөн БЕГ-төслийн тайлант үйл ажиллагаанд нийслэл, Баянхонгор Завхан, Сүхбаатар, Дундговь аймгийн нийт 13 сургуулийг хамарсан 5 багш, ажилтан хамрагдсан. 34-р сургуультай багш солилцоо хийж Хэнтий аймгийн дадал суманд болсон хамтын ажиллагааны хөтөлбөрт арга хэмжээнд оролцсон.

**10. Сургуулийн "Сургуулийн менежмент", Номын сангийн орчин сургалт**

Дэлгэрхангай суманд “Сургуулийн менежмент” сургалтанд сургуулиас 8 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдсан.

**11. Англи хэлний багш нарыг чадавхжуулах сургалт**  
БШУГ-аас зохион байгуулсан англи хэлний багш нарыг чадавхжуулах онлайн сургалт 7 багш хамрагдав.

**12. Физикийн багшийг чадавхжуулах ЭЕШ-д бэлтгэх аргазүй, онолын сургалт**

Монголын физикчдийн үндэсний сургалт зөвлөгөө 08.21-24-ны хооронд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан. Тус сургалтанд физикийн багш Б.Анхцэцэг хамрагдсан.

**13. Дэлгэрхангай суманд болсон баруун бүсийн “Ур чадварын” хичээл, сургалт**

|   |                                       |                |   |    |   |  |      |
|---|---------------------------------------|----------------|---|----|---|--|------|
|   |                                       |                |   |    | <p>Дэлгэрхангай суманд зохион байгуулагдсан баруун бүсийн багш нарын “Ур чадвар”ын уралдаанд математикийн багш Д.Одонтуул, МХБУЗын багш Ш.Баасансүрэн, Дизайн технологийн багш Г.Энхтуяа нарыг оролцуулан 3-р байр эзэлсэн амжилт үзүүлсэн. Энэхүү арга хэмжээний үеэр зохион байгуулагдсан “Сургуулийн менежмент” сургалтанд сургуулиас 8 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдсан.</p> <p><b>14. Шинэ Эрин сургуулийн захирал Наранбаатар сургалтууд, хамтын ажиллагаанд тус тус хамрагдаж туршлага судалсан.</b></p> <p>Шинэ Эрин сургуулийн захирал Наранбаярын сургуулийн менежментийн сургалт, мөн баруун бүсийн багш нарын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хамтын ажиллагаанд тус тус хамрагдаж туршлага судалсан.</p> |  |      |
| 7 | Сургуулийн менежментийг сайжруулах нь | Онлайн сургалт | 0 | 6  | -   | <p>Vi системийн нэгдсэн мэдээллийн сургалтын чанар,сурагчдын хөгжил хамгаалал, багшийн тасралтгүй хөгжил ,сургалтын орчин , удирдлагын манлайлал,сургуулийн талаархи хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн сургуулийн менежментийг хэрхэн сайжруулах талаар сургалтанд сургуулийн захирал Л.Буянтогтох, сургалтын менежер Ж.Гарамханд нар хамрагдлаа. Өөрийн сургуулийн тулгамдсан асуудал, шийдэх арга замаа тодорхойлж, оновчтой, үр дүнтэй, хэрэгжихүйц үйл ажиллагаа төлөвлөж, хэрэгжүүлж, хичээлийн жилийн эцэст ажлын биелэлтээ тайлагналаа.</p> | 100% |
| 8 | Мэргэжил сонголтын талаарх сургалт    | Багшийн хөгжил | 0 | 35 | -   | <p>2023 оны 1-р сарын 20-нд УБ хотын Оюунлаг сургуулийн багш 9-р ангийн сурагчдаас хэрхэн мэргэжил сонголтын судалгаа авах талаар онлайн сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтанд 30 багш хамрагдсан. 9-р ангийн 109 сурагчдад АУБ нар сургалтыг зохион</p>  | 100% |

|    |  |                                    |   |    |   |  |      |
|----|--|------------------------------------|---|----|---|--|------|
|    |  |                                    |   |    |   | байгуулсан. Сургалтын үр дүнгээр 9-р ангийн 105 сурагчаас мэргэжил сонголтын судалгааг авч нэгтгэлээ.  |      |
| 9  | Азийн физикийн олимпиадын бэлтгэл сургалт            | Физикийн багш нарт                 | 0 | 2  | - | Азийн физикийн олимпиадад зориулсан физикийн шинжлэх ухааны хөгжил дэвшлийг амжилт олон нийтэд таниулан мэдээлэл өгөх нээлттэй өдөрлөг бэлтгэл сургалтанд 03 сарын 27-нд БШУГ-т 1 багш хамрагдсан.   | 100% |
| 10 | ЭЕШ-д зориулсан ахлах, дунд ангийн багш нарт сургалт | Сургагч багш нар                   | 0 | 20 | - | Оюунлаг сургуулиас зохион байгуулсан ЭЕШ-д бэлтгэж байгаа багш нарын мэдлэг, ЭЕШ-д бэлтгэж байгаа агуулга, агуулга дээр хэрхэн ажиллах вэ сургалтанд 10 судлагдахууны 16 багш хамрагдсан. Сургалтанд хамрагдсанаар багш нар ЭЕШ-д хэрхэн бэлтгэж анализ хийн ажиллах, суралцагчидтайгаа хэрхэн хамтран ажиллах талаар туршлага хуримтлуулан авч ажилласан.   | 100% |
| 11 | Хими, физик, биолог, м/х, мат, англи хэл             | Мэргэжлийн багш нар                | 0 | 18 | - | "Багшийн болон сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий үр дүнд хийсэн дүн шинжилгээ, цаашид анхааруулах асуудал " сэдэвт танхимын сургалт 2023 оны 1-р сарын 11-13 нд ДУ аймагт болж байгалийн ухааны болон бусад мэргэжлийн 25 багш хамрагдсан.  | 100% |
| 12 | Үндсэн сургалт                                       | 1,5,10 жил ажиллаж байгаа багш нар | 0 | 6  | - | 1,5,10 жилийн мэргэшүүлэх сургалтад танхим болон цахимаар 13 багш хамрагдсан.  | 100% |
| 13 | Захирал, эрхлэгч ,ня-бо нарын сургалт хэлэлцүүлэг    | Төсвийн шинэчлэл                   | 0 | 3  | - | "Үр дүнд чиглэсэн гүйцэтгэлд суурилсан боловсролын салбарын төсвийн шинэчлэл " сэдэвт сайн туршлага судлах, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хэрэгжилт, үр дүнг тооцох тайлан-хэлэлцүүлгийн хурлыг 2023 оны 3 дугаар сарын 30 нд дундговь аймагт хийлээ. Уг хуралд 19 сургууль 22 цэцэрлэгийн удирдлага нягтлан бодогч нар хамрагдсан. Тайланг санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй 10 шалгуур үзүүлэлтээр дүгнэсэн. | 100% |

|    |                                      |                         |    |    |   |   |      |
|----|--------------------------------------|-------------------------|----|----|---|---|------|
| 14 | Энх тайваны боловсрол сэдэвт сургалт | Багшийн хөгжил          | 69 | -  | - | HWPL Олон улсын байгууллагын Монгол дахь салбараас "Энх тайвны боловсрол" сэдэвт сургалтыг 2023 оны 03 сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад 59 багш болон Адаацаг сумын ЕБС-ийн 10 багш хамрагдлаа.  | 100% |
| 15 | Хүүхэд хамгааллын тухай хууль        | Багш, ажилтан хамрагдах | 92 | 92 | - | Жил бүр хүүхэд хамгааллын ажлын хүрээнд 1-12-р ангийн бүх сурагчдад эрсдлийн үнэлгээ хийж ажилладаг. Үнэлгээгээр өндөр , дунд эрсдэлтэй гарсан сурагчидтай АУБ, эцэг эхтэй хамтран ажилладаг. ТАХ, эцэг эхчүүдийн төлөөлөл 60 гаруй иргэд, албан байгууллага аж ахуйн нэгж, төрийн албан хаагчдад “Хүүхэд хамгаалалын бодлогын журам”-ын талаар мэдээлэл сургалт явуулж, эцэг,эх,асран хамгаалагчийн эрх, үүрэг, боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын бодлого, сурагчдын эрх,үүрэг зэргийг тусгасан брошур,зурагт хуудсыг тараан иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан. | 100% |
| 16 | Харилцаа                             | Багш, ажилтан хамрагдах | 92 | 92 | - | Хандлагаа өөрчилье, хамтдаа хөгжье аян зохион байгуулж хамт олны уур амьсгалыг эерэг болгохоос гадна төсөвт байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор байгууллага бүртэй зохион байгуулсан. Сурагчдын дунд "Харилцаа" сэдэвт сургалтыг зохион байгуулж багшаас тавьсан шаардлагыг хэрхэн зөв ойлгох, эерэг байх талаар ойлголт мэдээлэл өгсөн.   | 100% |
| 17 | Ёс зүйн сургалт                      | Багш, ажилтан хамрагдах | 92 | 92 | - | Байгууллагын багш, ажилтантай ёс зүйн гэрээг байгуулан ажилладаг. Энэ хичээлийн жилд шинээр ажилд орсон 7 багштай ёс зүйн гэрээг шинээр байгуулж ажилласан. Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас багш нарын ёс зүй, харилцааны талаар авсан сэтгэл ханамжийн судалгааны дүнг багш бүрт ганцаарчилан танилцуулж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.   | 100% |



|    |                                       |                   |   |    |  |      |
|----|---------------------------------------|-------------------|---|----|--|------|
| 18 | Багш нарыг<br>чадавхжуулах<br>сургалт | Багшийн<br>хөгжил | - | 11 | <ul style="list-style-type: none"> <li>- "Багшийн хөгжлийг дэмжих" сургалтаар ЭХЦК-д суурилсан сургалтын арга зүй, агуулгад багш бүтээлчээр суралцах , Боловсролын чиг хандлага ба багшлахуйн зарим асуудал, ЭХЦК-ын оролцоо ба хэрэглээ гэсэн агуулгаар баруун бүсийн сургуулиудын 201 багш хамрагдлаа.Тус сургалтыг Гавъяат багш Ө.Цэндсүрэн, Д.Түвшинжаргал, Л.Мөнхзул нар удирдан зохион байгуулсан.</li> <li>- Залуусын оролцоо уур амьсгалын өөрчлөлт” сургалтанд 08 сарын 25-нд сургуулийн захирал, сургалтын менежер нар тус тус хамрагдсан.</li> <li>- Дотуур байрын хүүхдийн аюулгүй байдал, хөгжил хамгаалалт” сургалтанд 08 сарын 30-нд аймгийн БШУГ-т дотуур байранд багш хамрагдсан.</li> <li>- 10 сарын 30-нд “Удирдлагын манлайлал” удирдах албан хаагчдын сургалт, 2 өдрийн зөвлөгөөнд сургуулийн захирал хамрагдав.</li> <li>- Сургуулийн дэмжлэгийн багийн гишүүдэд “Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхэдтэй ажиллах арга зүй сургалтанд 11 сарын 17нд цахимаар дэмжлэгийн багийн гишүүд хамрагдсан.</li> <li>- БШУГ-ын хоол үйлдвэрлэлийн газраас “Хүүхдийн хоолыг хүнсний ногоогоор баяжуулах ач тус технологи сэдэвт” сургалтанд 08 сарын 26-ны өдрүүдэд 1 тогооч, хоол зүйч нар хамрагдсан.</li> <li>- . Солонгос улсад 1, хятад улсад 2 албан хаагч, ОХУын Эрээн хотод 1 багш тус тус 08, 09 сард туршлага солилцох сургалт, семинар, уулзалтанд хамрагдсан.</li> </ul> | 100% |
|----|---------------------------------------|-------------------|---|----|--|------|

|  |  |  |  |  |  |   |  |
|--|--|--|--|--|--|---|--|
|  |  |  |  |  |  | <p>- Аймгийн насан туршийн суралцахуйн төвөөс “Сургуулийн насны хүүхдийн сургууль засвардсан шалтгааны судалгааг авах зөвлөгөө цахим сургалтанд 10 сард насан туршийн суралцахуйн багш Б.Өнөржаргал хамрагдсан.</p> <p>- 12 сарын 1-нд Дундговь аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар аймгийн ИТХурлаас зохион байгуулсан. Өсвөрийн сэргийлэгч сургалтанд нийгмийн ажилтан Б.Оюунтөгс хамрагдсан.</p> |  |
|--|--|--|--|--|--|---|--|

**НЭГТГЭСЭН**  
**БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН**  
**ХЯНАСАН**  
**СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ**

**Б.ОТГОНЖАРГАЛ**  
**Л.БУЯНТОГТОХ**